

НИСЛЭГИЙН ЦАГ УУРЫН ТӨВИЙН
2019 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2019.02.02

Мэдээлэл үйлчилгээний талаар:

2019 оны 01 дүгээр сард “Чингис хаан” олон улсын нисэх буудал орчмын богино хугацааны урьдчилсан мэдээ /TAF/ мэдээ 204, урт хугацааны урьдчилсан мэдээ 126, районы урьдчилсан мэдээ 202, угталтын урьдчилсан мэдээ 143, өндрийн салхины урьдчилсан мэдээ 248, аэродромын урьдчилсан мэдээ 62, SIGMET мэдээ 6, Тосонцэнгэл нисэх буудал орчмын богино хугацааны TAF 64, хөөрөлтийн урьдчилсан мэдээ 198, Ханбумбат нисэх буудлын TAF 153, Овоот нисэх буудлын TAF 22, бусад нисэх буудлын урьдчилсан мэдээ 10 удаа тус тус гаргаж, олон улсын 692, орон нутгийн 440, онцгой ба тусгай үүргийн 6 нислэгийг 299 чиглэлийн урьдчилсан мэдээ болон цаг агаарын төрөл бүрийн мэдээ мэдээллээр үйлчилсэн байна. Хэрэглэгчдийн хүсэлтийн дагуу цаг агаарын зөвлөгөөг утсаар болон цахимаар өгч байна. Төв орон нутгийн 5594 бодит мэдээ, 1879 урьдчилсан мэдээг хүлээн авч дамжуулсан байна. 1 дүгээр сард Европын дунд хугацааны тоон прогнозын зураг, Япон, Солонгосын прогноз зураг, болон өндрийн цаг агаарын зураг /850гПа, 700гПа, 500гПа, 300 гПа, ОТ 1000:500/, газрын цаг агаарын зураг, орчны цаг агаарын бодит зураг, онцгой үзэгдлийн зураг, олон улсын нислэгт зориулж салхи температурын орны зураг, FY-2C болон Himawaricast японы хиймэл дагуулын үүлний зураг тус тус хүлээн авч мэдээ зохиолт болон нислэгийн үйлчилгээний ажилд ашигласан. WAFS бүтээгдэхүүнүүд хэвийн.

36 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүнг боловсруулж, 7 хоногийн төлөв гаргахад зориулж 168 цагийн урьдчилалтай тоон загварын үр дүн, стандарт өндрүүдийн салхи температурын орны зургуудыг тус тус урьдчилсан мэдээ зохиолт, нислэгийн үйлчилгээнд ашиглаж байна.

Чингис хаан ОУНБ орчмын урьдчилсан мэдээний таарц, нислэгийн саатал:

Энэ сард нийт цаг агаараас шалтгаалсан нислэгийн 10 саатал гарсан байна. Үүнд: мэдээ таарсан 9, таараагүй урьдчилсан мэдээ 1, /2018 оны 1 сард нийт 6 саатал гарсан, таарсан 5, таараагүй 0/

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад богино хугацааны урьдчилсан мэдээний таарц 0.36%-иар буурч, урт хугацааны урьдчилсан мэдээний дундаж таарц 1,58%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Нислэгийн цаг уурын өртөөний нислэгт зориулсан буудал орчмын бодит мэдээ 1364, уур амьсгалын мэдээ 248, аюул-1, агаар-1, климат мэдээ-1, сарын дундаж мэдээ-4 дамжуулж, харьцуулсан ажиглалт 23 удаа хийж нислэгийн аюулгүй ажиллагааг хангаж ажилласан.

Орон нутгийн нислэгийн үйлчилгээний ажлын талаар:

Энэ сард үндсэн буудлын 306, бэлтгэл буудлын 982 нислэгийг 94.1-100%-ийн таарцтай мэдээгээр үйлчилсэн байна. Орон нутагт цаг агаараас шалтгаалж 3 нислэгийн саатал гарсан. Алтай, Өлгий, Ханбумбатад нисэх буудалд салхитай байснаас хүлээсэн, 2-т гарсан ба урьдчилсан мэдээний таарц нь салхины хурдаар 33,3-66,7%-тай ба мэдээ таараагүй байна. Төв, орон нутгийн нисэх буудлуудын буудал орчмын бодит болон урьдчилсан мэдээ, чиглэлийн урьдчилсан мэдээ, нисэх буудал орчмын 7 хоногийн төлөвт хяналт тавьж, 4 удаа хариу зааварчилгаа хүргүүлсэн.

Орон нутгийн УЦУОШТ-үүдийн нислэгийн цаг уурын үйлчилгээний тайланг нэгтгэж, Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын удирдах ажилтны семинарын үеэр танилцуулсан.

Сүлжээ, тоног төхөөрөмжийн талаар:

1 дүгээр сарын 11-нд Шинэ нисэх буудлын нислэгийн удирдагчийн байрнаас шинэ нисэх буудал (РТВ) руу холбогдсон шилэн кабелийн холболтын үзүүрийг 104 тоот өрөө рүү оруулсан. Ингэснээр шинэ нисэх буудалд цаг уурын зураг мэдээний солилцоонд ашиглах сүлжээг ашиглах боломжтой болсон.

1 дүгээр сарын 23-нд PowerEdge T320 веб серверт үйлчилгээ хийсэн. WRF тоон загварчлалын сервер дээр боловсруулсан үр дүнг зураглах ажлыг хийж байна.

Удирдлага, санхүү:

01 дүгээр сарын 28-31-ний өдрүүдэд Ерөнхий технологич инженер Говь-Алтай аймгийн УЦУОШТ болон нисэх буудалд төлөвлөгөөт үзлэг шалгалт явуулж, зааварчилгаа зөвлөмжөөр хангасан. ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 24 дүгээр тогтоолын холбогдох хавсралт, журмын дагуу албан хаагчдын албан тушаалын цалин, ур чадварын болон мэргэшлийн зэргийн нэмэгдлийг шинэчлэн тогтоож, 2019 оны 1 дүгээр сарын 01-нээс тооцож олгохоор төвийн даргын А/03 тушаал гарсан.

29-нд БОАЖЯ-наас явуулж байгаа ЗГ-ын 24 дүгээр тогтоолоор тогтоосон цалингийн судалгаа, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар дахин үнэлүүлэх хөрөнгийн (барилга байгууламж-4, инженерийн байгууламж-2) судалгааг гаргаж хүргүүлсэн.

“Чингис хаан” ОУНБ-тай хамтран ажиллах гэрээ дүгнэх уулзалтыг 1 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж, гэрээг 1 жилээр сунгасан. МИАТ ХК-тай гэрээ дүгнэсэн хурлын протоколыг 25-нд ирүүлсэн. Хүннү эйр ХХК-тай байгуулсан гэрээнд 2 талаас нэмэлт өөрчлөлт оруулах саналгүй тул протоколоор 2019 оны 2 сарын 01-нээс 1 жилээр сунгасан.

ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанаас Иргэний Нисэхийн Дүрэм-174-ээр гэрчилгээжсэн тус төвийн гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгах төлөвлөгөөт үзлэг шалгалтыг 2019 оны 2 дугаар сарын 13-20-ны өдрүүдэд явуулахаар удирдамж ирүүлж, бэлтгэл ажлууд хийгдэж байна.

Сургалт дадлага, хурал, семинар:

Хөсвгөл аймгийн УЦУОШТ-д синоптик инженерээр ажиллах 1 ажилтан урьдчилан мэдээлэх чиглэлээр, Говь-Алтай, Өвөрхангай аймгийн УЦУОШТ-өөс 2 ажилтан нисэхийн цаг уурын техникчээр үйлдвэрлэлийн дадлага хийж, дадлагын шалгалт болон нислэгийн цаг уурын мэргэшлийн үнэмлэх олгох шалгалт өгч тэнцсэн.

Баян-Өлгий аймгийн УЦУОШТ-д синоптик инженерээр ажиллах Б.Айнур үйлдвэрлэлийн дадлага хийж байна.

1 дүгээр сарын 8, 10-ны өдрүүдэд Хүннү эйр ХХК-ийн хүсэлтээр нисэх бүрэлдэхүүнд “Үүл, хур тунадасны хэлбэр, алсын барааны харагдац, RVR, сэгсрэлт, салхи, газар өндрийн ажиглалтууд, MET reports, урьдчилсан мэдээнүүд, сэрэмжлүүлэг мэдээ, прогноз зураг унших задлах, бүс нутгийн цаг агаарын онцлог, шилжлэг салхи, аянга цахилгаан түүний нөлөөллөөс зайлсхийх, мөстөлт, мөстөлтийн үед авах арга хэмжээ” зэрэг сэдвүүдээр нийт 6 цагийн сургалт явуулсан.

Дүгнэлт:

Нислэгийн цаг уурын төвийн 2019 оны 01 дүгээр сарын шинжилгээ, мэдээлэл үйлчилгээ, тоног төхөөрөмжийн ажиллагаа “Хэвийн” явагдсан.

Нислэгийн цаг уурын төв